

МОНГОЛ УЛСАД БНСУ-ЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ АСУУДАЛД

*Д.Начин**

БНСУ-ын эдийн засгийн глобалчлал, бүс нутгийн интеграцчлалд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг роль судлаачын (Баатар 2004) тодорхойлсноор улам нэмэгдэж байгаа бөгөөд Монгол Улстай байгуулсан харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт богино хугацаанд хамгийн эрчимтэй хөгжиж байна. Энэ өгүүлэлд БНСУ-ын хөрөнгө оруулалт, худалдааны тухай өгүүлэх болно.

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах гадаад, дотоодын (МУЗГ 2002) эрх зүйн таатай орчин бүрэлдэн тогтож, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдсээр байгаа (Начин 2004а, 2004б) бөгөөд үүний дотор БНСУ-ын хөрөнгө оруулалт ч орох юм.

Монгол Улсын Засгийн газар нь БНСУ-ын Засгийн газартай 1991 оны 3 дугаар сарын 28-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т гарын үсэг зурж мөн оны 4 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон нь БНСУ-ын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн үндэс, хүчин зүйл болсон байна.

2003 оны эцсийн байдлаар Монгол Улсад орсон гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн дүнгээр нэг тэрбум гаруй ам.долларт хүрч БНХАУ, БНСУ, ОХУ, Япон, ХБНГУ, АНУ зэрэг улсуудаас хамгийн олон компани бүртгэгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ (42.7%), БНСУ (10.8%), Япон (7.3%), АНУ (5.4%), /газрын тосны салбар ороогүй/, ОХУ (4.7%) болон бусад 22.7% орнууд тэргүүлж байв. 2003 оноос газрын тосны хөрөнгө оруулалтыг тооцох болсноор БНХАУ-ын (37.9%) хөрөнгө оруулагчдын дараа Канад (13.2%), АНУ (11.4%), БНСУ (8.1%), Япон (6.0%), ОХУ (3.3%) -ын хөрөнгө оруулагчид орох болов.

БНСУ-ын хөрөнгө оруулагчид 1994 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд сүүлийн үед үйлдвэрлэл, үйлчилгээний олон салбарыг сонирхон хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсээр байгаа болно. БНСУ-ын нийт хөрөнгө оруулалт (80.8 сая ам. доллар)-ыг салбар тус бүрээр авч үзвэл, уул уурхайн салбарт 16% (12,9 сая ам.доллар), худалдаа нийтийн хоолны салбарт 12,7% (10,2 сая ам.доллар), хөнгөн үйлдвэрийн салбарт 8,3% (6,7 сая ам.доллар), тээврийн салбарт 7,1% (5,7 сая ам.доллар), харилцаа холбооны салбарт 6,6% (5,3 сая ам.доллар), инженерийн барилга байгууламж, барилгын материалын

*Д.Начин - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ахлах мэргэжилтэн

үйлдвэрлэлийн салбарт 5,3% (4,3 сая ам.доллар) тус тус орж, худалдаа, үйлчилгээ, тээвэр, хөнгөн үйлдвэрийн салбар компанийн тоогоороо тэргүүлж байна. Монголд хөрөнгө оруулалт хийсэн Солонгосын томоохон хөрөнгө оруулагчдаас Тай-Үл, Кореа Телеком, Самик, СК Телеком, Тү Март зэрэг корпорациудыг дурьдаж болох юм.

2003 онд БНСУ-ын хөрөнгө оруулагчид нийт 125 компани 6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр бүртгүүлээд байна. БНСУ-аас хийгдэж буй шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөн нэмэгдэж байгаа нь манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа цаашид ч өргөжин тэлэх боломжтойг харуулж байна.

Эдгээрээс харилцаа холбооны үүрэн телефоны Скайтел компани нь эдүгээ нийт хэрэглэгчдийн гуравны нэг орчимд үйлчилгээ үзүүлж байна. Трост энд Глори, Волдтрейдинг зэрэг компани оёдлын үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гадаад зах зээлд гарч байна.

Монголд хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулах боломж, бизнесийн үйл ажиллагаа явуулах муугүй нөхцөл байгааг харуулсан, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Монголд БНСУ-ын хөрөнгө оруулалттай нилээд хэдэн компани автомашины засвар үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа эрхлэдэг бөгөөд эдгээрээс Монгол Хьундай киа, Хьундай мотор зэргийг дурьдаж болно.

БНСУ-ын хөрөнгө оруулагчид нь эрүүл мэнд, соёл, боловсролын салбарт анхаарч ирсэн бөгөөд Ёнсей эмнэлэг, Улаанбаатар коллеж зэрэг нь олны танил болсон байна. Мөн түүнчлэн шинжлэх ухаан, технологийн МК интернэйшнл Солонгосын хөрөнгө оруулалттай компани нь Хар ямааны ханд бүтээгдэхүүнээ БНСУ-ын зах зээлд гаргаж эхлэсэн.

БНСУ-ын хөрөнгө оруулалттай Чингис жоурнэй, Дидо тоур зэрэг олон компаниуд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж БНСУ-ын жуулчдыг Монголтой танилцуулж байгаа болно.

Аялал жуулчлал, худалдаа, уул уурхайн салбарыг БНСУ-ын хөрөнгө оруулагчид сонирхож байгаа болно. БНСУ-ын хөрөнгө оруулалттай Джи Эйч Эм, Би энд Жи Эквивмэнт, Трост энд Глори, Волдтрейдинг, Сөүлконстракшн, Сөүл модерн хаузинг, Бэгду констракшн, КМТР, Сити такси, Скайтрейдинг зэрэг компаниуд нь 2000-2003 онуудад 100 мянган ам.доллараас дээш хөрөнгө оруулалтыг геологи хайгуул, уул уурхай, оёдол, барилгын үйлдвэрлэлд хөрөнгө нэмж оруулсан болно.

Геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт ийнхүү ихээхэн хэмжээний хөрөнгө дахин оруулах болсон нь Монгол Улсын Засгийн газраас энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн тодорхой алхмууд, тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг (МУЗГ 2001) 2001 онд, “Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл” (МУЗГ 2002а), “Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл” (МУЗГ 2002б) зэргийг 2002 онд баталсантай холбоотой гэж үзэж байна. Энд алт, зэсний ихээхэн нөөцтэй Оюу Толгойн ордыг ашиглалтанд оруулснаар Монгол Улсын ДНБ 2-3 дахин өснө гэсэн тооцоо байдгийг дурьдая.

Монгол Улсын төр засгаас уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг гадаадын хөрөнгө оруулалтыг татах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарууд гэж тодорхойлдог бөгөөд дээрх салбаруудад хөрөнгө оруулалт хийхэд тодорхой дэмжлэг, урамшууллыг үзүүлдэг. Тухайлбал, Засгийн газраас 2001 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын жагсаалтын дагуу үр тариа, эрчимжсэн мал аж ахуй, нүүрс, газрын тос, ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэл, үслэг эдлэл, арьс шир боловсруулалт, мод, модон эдлэл, төмөрлөг, химийн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эдийн боловсруулалт, дэд бүтцийн зарим салбар, аялал жуулчлал зэрэгт хамаарагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд гадаадаас орж ирж буй технологийн зориулалттай тоног төхөөрөмж нь НӨТ, гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

Уул уурхайн салбарт БНСУ-д үйлдвэрлэсэн уул уурхайн ДЭҮ тоног төхөөрөмжүүд сүүлийн жилүүдэд Монголд нийлүүлэгдэх боллоо.

Энэ дашрамд манай улсын БНСУ-тай хийж байгаа худалдааны талаар товч боловч өгүүлэх нь зүйтэй болов уу гэж үзлээ. Манай гадаад худалдааны гол түнш орнууд нь Зүүн Азийн улсууд хэвээр байгаа бөгөөд 1999 оноос БНХАУ-тай хийх худалдаа, ялангуяа экспортын хувьд зонхилох болж, харин нефть бүтээгдэхүүний дийлэнхийг ОХУ-аас авдаг учир импортын хувьд энэ орон тэргүүлж байна. Харин БНСУ нь манай улсын гадаад худалдааны харьцангуй шинэ түнш боловч сүүлийн жилүүдэд идэвхижин худалдааны нийт эргэлтээр эхний 4, 5 дугаар байранд орох болсон байна. (хүснэгтийг үзнэ үү) Ийм идэвхитэй худалдаа нь 1998 онд Солонгосын воны ханш буурснаас үүдэлтэй бөгөөд энэ үеэс эхлэн импортын хэмжээ БНСУ-д экспортлох хэмжээнээс давах болсон байна. БНСУ-аас өргөн хэрэглээний бараанаас гадна үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай янз бүрийн тоног

төхөөрөмж, багаж хэрэгслэл импортлож байгаа бөгөөд эдгээрийн төлбөрийн тодорхой хэсгийг БНСУ-д ажиллаж байгаа манай ажилчдаас хийж байгаа нь тодорхой.

Энэ бүгдээс үзэхэд БНСУ-ын хөрөнгө оруулалт Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрийн зохих хувь нэмрээ оруулж байгаа бөгөөд дараах хүчин зүйлд тулгуурлан цаашид ч өсөн нэмэгдэх болно гэж үзэх үндэслэл байна. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд өсөх хандлага тогтворжин ДНБ-ий өсөлт 2003 онд 5.5 хувьд хүрсэн тул 2003 оны 11 дүгээр сард Токио хотноо зохиогдсон Монголд хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалтаас манай орныг шилжилтийн үеэс өсөлтийн үед шилжсэн гэж дүгнэсэн. (ADB 2003)

- Гадаадын хөрөнгө оруулагчдын хэзээд болгоомжилдог байсан Монголын төсөвт санхүүгийн тооцоолоогүй дарамт гарч ирэн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх нэгэн “эрсдэл” - Монгол Улс, ОХУ-ын хооронд он дамнан яригдсаар ирсэн “их өрийн” асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн.

- Нөгөөтэйгүүр Европ, Америк төвтэй дэлхийн уламжлалт зах зээл Ази, тэр дундаа БНХАУ руу чиглэн шилжиж байгаа үед энэхүү том зах зээлд нэвтрэх үүднээс гадаадын хөрөнгө оруулагчдад худалдааны либерал бодлого, тогтолцоотой Монголыг сонирхох сонирхол нэмэгдсэн явдал юм.

- НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас хийсэн судалгааны үр дүн болох 2003 оны Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд Монгол Улс нь ГШХО орох өндөр чадавхтай орнуудын тоонд багтсан. (UNCTAD 2003, 2004)

Манай орны хувьд ДНБ-ий өсөлтөөс гадна ГШХО орох чадавхийн индексийг тодорхойлсон үзүүлэлтүүд (тухайн орны ДНБ-ний бодит өсөлт, нэг хүнд оногдох ДНБ, нийт экспорт, 1000 хүнд ногдох телефон утасны шугам, гар утасны тоо, арилжааны цахилгаан эрчим хүч хэрэглэх төвшин, судалгаа-шинжилгээнд гаргаж байгаа зардал, оюутны тоо, байгалийн баялгаа экспортлож байгаа болон электроникийн эд анги, автомашин импортлож байгаа байдал, ажил үйлчилгээний экспорт ба ГШХО-ын нийт хэмжээ зэрэг)-ийг тодорхойлсон байна. (UNCTAD 2003) Үүнийг сайжруулах, ядаж хүрсэн хэмжээнд нь барьж байх шаардлагатай бөгөөд энэ үзүүлэлтүүдээс телефон утас, гар утас, их дээд сургууль, коллежийн оюутны тоо нэмэгдэж байгаа, эрсдэлийн зэрэг буурч байгаа зэрэг нааштай зүйл бий. Мөн түүнчлэн, эрдэм шинжилгээний ажилд зарцуулж болох хөрөнгийн хэмжээтэй холбогдсон үзүүлэлтүүд нь эерэгээр нөлөөлж болох талтай. Энд мэргэжилтэй ажилчид, инженер, техникчдийг бэлтгэх асуудал чухал юм.

Монгол Улсын ДНБ-д тээвэр, агуулахын аж ахуй, холбооны (16.5), санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны (13.5), барилгын (12.6) зэрэг салбарын нийт бүтээгдэхүүний өсөлт (ҮСГ 2004) өндөр хувьтай байгаа бөгөөд эдгээр салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсээр байгаа болно.

Тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарт багтаж байгаа мэдээлэл, холбооны салбарын нийт бүтээгдэхүүний өсөлт 14.5 хувь буюу ДНБ-ийхээс бараг 3 дахин илүү хурдацтай байгаа бөгөөд жилийн нийт орлогын хэмжээ 2003 онд 92.4 тэрбум төгрөгт хүрч 1999 оныхтой харьцуулахад бараг 4 дахин өсчээ. (Энхбаяр 2004) Энэ өсөлтийг жил дараалан нэмэгдэж байгаа суурин телефон цэг, гар утас хэрэглэгчдээс гадна өнөөдрийн байдлаар 11.2 мянгад хүрээд байгаа интернет хэрэглэгчтэй холбон үзэхээс гадна салбарын орлогыг нь холбоо (телефон, гар утас) болон мэдээллийн технологид хэрхэн хувиарлагдаж байгааг харах нь чухал. Холбооны дэд салбарын хувьд хэрэглэгчдийн тоо, үйлчилгээний нэр төрөл, тариф нь хязгаартай учир орлогын өсөлт тодорхой хэмжээнээс хэтрэхгүй болно. Харин мэдээллийн технологийн дэд салбарын хувьд орлого нь огцом өсөх боломжтой.

Сүүлийн үед ажил үйлчилгээний экспортод хэдэн зуун тэрбум ам.доллараар хэмжигдэх зах зээлтэй компьютерийн програм хангамж чухал байр эзлэх болсон бөгөөд гол захиалагч нь АНУ, Япон, ХБНГУ, Их Британи зэрэг хөгжингүй орнууд бөгөөд Энэтхэг, БНСУ-ын програм зохиогчид энэ зах зээлийн үндсэн гүйцэтгэгчид нь болдог байна.

Компьютерийн програм хангамжийн үйлдвэрлэл нь орчин нөхцөл нь бүрдсэн тохиолдолд ажиллагсадын тоо, газар зүйн байршил, эдийн засгийн хүчин чадлаас үл хамааран богино хугацаанд хөгжилд хүргэж чадах бизнес юм.

Цөөн хүн амтай, жижиг эдийн засагтай, газар зүйн өвөрмөц байршил, өргөн уудам нутаг дэвсгэртэй учир тээврийн өндөр зардалтай манай орны хувьд компьютерийн програм хангамжийн экспортод онцгой анхаарал хандуулж судлах, улмаар шинээр бий болгож хэрэгжүүлэх нь улс орны хөгжлийн зангилаа асуудлын нэг юм.

Сүүлийн үед манай компьютерийн програмын зарим нэгэн компани бие даан эсвэл гадаадын компанийн салбарыг Монголд байгуулж бага хэмжээний захиалгат програм боловсруулах, тест хийх ажлыг хийж байна. Эдгээрээс гаалийн системд хэрэглэж байгаа GAMAS, зарим банкуудад хэрэглэж байгаа GLAXY, их дээд сургуульд хэрэглэж байгаа UNIMIS, олон улсын байгууллагын төслийн IMIS (Integration Management Information System), MONIS (Monitoring Information System) зэрэг систем нь гадаадын програм зохиогчдоос зохих ёсоор үнэлэгдсэн, тодорхой түвшинд хийгдсэн ажил болсон байна. Иймд энэ салбар нь гадаадын

хөрөнгө оруулагчид, ялангуяа БНСУ-ын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах чиглэлийн нэг байж болох юм.

Даяарчлагдаж байгаа нөхцөлд барууны хөрөнгө оруулалтыг Монголын өрсөлдөх чадварыг бий болгох, технологийн шинэчлэл, дэвшилтэт шинэ технологи дамжуулан авахад чиглүүлэх (Начин 2004в) нь улс орны хөгжлийн зангилаа асуудлын нэг хэмээн үзэж түүнийг татах асуудалд Монгол Улсын төр засаг онцгой анхаарах шаардлагатай байна.

БНСУ-ын хөрөнгө оруулагчдыг Монголын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дэвшилтэд технологи, хүрээлэн буй орчинд хал багатай технологи нэвтрүүлэхэд татах, ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний гүн боловсруулалт, эрчимжсэн хөдөө аж ахуй болон шинжлэх ухаанд суурьлагдсан, ялангуяа биотехнологи, мэдээллийн технологийн чиглэлийг илүү анхаарах нь оновчтой байж болох юм.

Монгол Улсын зарим орнуудтай хийж байгаа гадаад худалдаа /сая ам.доллар/

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
ОХУ (нийт эргэлт)	242.4	212.5	190.8	198.0	251.3	241.6	285.6	306.6
экспорт	87.5	46.6	40.6	48.2	45.1	39.7	48.0	41.2
импорт	154.9	165.9	150.2	149.8	206.2	201.9	237.6	265.4
баланс	-67.4	-119.3	-109.6	-101.6	-161.1	-162.2	-189.6	-224.2
БНХАУ (нийт эргэлт)	147.0	164.9	176.7	285.8	400.1	333.8	356.8	456.5
экспорт	81.0	101.6	110.1	208.2	274.3	212.4	217.3	284.2
импорт	66.0	63.3	66.6	77.6	125.8	121.4	139.5	172.3
баланс	+15.0	+38.3	+43.5	+130.6	+148.5	+91.0	+77.8	+111.9
Япон (нийт эргэлт)	112.8	72.5	71.9	125.9	81.4	65.4	49.1	71.9
экспорт	35.0	37.7	12.6	10.9	8.1	12.6	6.3	8.5
импорт	77.8	34.8	59.3	115.0	73.3	52.8	42.8	63.4
баланс	-42.8	+2.9	-46.7	-104.1	-65.2	-40.2	-36.5	-54.9
АНУ (нийт эргэлт)	28.9	62.0	65.8	77.8	121.3	98.6	189.1	166.5
экспорт	17.8	25.4	29.4	46.3	92.9	84.7	165.7	143.0
импорт	11.1	36.6	36.4	31.5	28.4	13.9	23.4	23.5
баланс	+6.7	-11.2	-7.0	+14.8	+64.5	+70.8	+142.3	+119.5
БНСУ (нийт эргэлт)	52.0	65.3	70.9	38.3	58.3	57.0	108.8	75.1
экспорт	34.0	44.3	33.2	2.1	2.7	3.4	22.5	7.5
импорт	18.0	21.0	37.7	36.2	55.6	53.6	86.3	67.6
баланс	+16.0	+23.3	-4.5	-34.1	-52.9	-50.2	-63.8	-60.1
Бүгд (нийт эргэлт)	875.2	919.8	848.4	871.1	1,080.6	940.0	1214.6	1416.9
экспорт	424.3	451.5	345.2	358.3	466.1	385.2	523.9	615.9
импорт	450.9	468.3	503.3	512.8	614.5	554.8	690.7	801.0
баланс	-26.6	-16.8	-158.1	-154.5	-148.4	-169.6	-166.8	-185.1

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар,
Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, ҮСГ, Улаанбаатар

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Баатар Ц., 2004, *Эдийн засгийн глобалчлал, бус нутгийн интеграцчлалд Өмнөд Солонгосын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг роль*, Олон Улс Судлал, 1, 2004, 61-75 хуудас
2. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2001, Төрийн Мэдээлэл 2001, # 34, Засгийн Газрын 2001 оны 140 дүгээр Тогтоол, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт батлах тухай, МУЗГ, Улаанбаатар
3. МУЗГ, 2002, Төрийн Мэдээлэл, 2002, №5, Гадаадын Хөрөнгө Оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль, МУЗГ, Улаанбаатар.
4. Начин Д., 2004а, Гадаадын шууд хөрөнгө оруулалт: Дэлхий дахины хандлага ба Монгол Улс, Олон Улс Судлал, 1, 2004, 51-60 хуудас
5. Начин Д., 2004б, *Монгол Улсын гадаад эдийн засгийн бодлогын хэрэгжилт: Гадаадын хөрөнгө оруулалт*, World Affairs (Олон Улсын Харилцаа), 2004, # 1 232(09), 107-121 хуудас, МУИС-ийн Олон Улсын Харилцааны сургууль, Улаанбаатар, Монгол Улс
6. Начин Д., 2004в, *Гадаадын хөрөнгө оруулалтыг шинжлэх ухаан, технологийн салбарт татах зарим асуудал*, Стратеги судлал, # 3, 2004, 178-189 хуудас, Стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
7. Энхбаяр Н., 2004, *Мэдээлэл, холбооны технологийн салбарын хөгжил*, Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаярын Монголын радиогоор хийсэн мэдээлэл, 2004.03.20. www.open-government.mn/battai/medeeteil
8. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), 2004, Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2003, ҮСГ, Улаанбаатар
9. The Asian Development Bank (ADB) 2003, *Report on the tenth consultative group meeting on Mongolia*, Tokyo, November 19-21, 2003. ADB.
10. <http://www.adb.org/Documents/Conference/IN309-03.pdf>
11. UNCTAD, 2003, World Investment Report 2003: *FDI Policies for Development: National and International Perspectives*, United Nations, New York and Geneva, 2003
12. UNCTAD, 2004, World Investment Report 2004: *The Shift Towards Services*, United Nations, New York and Geneva, 2003